

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Орон нутгийн төсвийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт шинээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хувьд 97 хувьтай, он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний хувьд 51.1 хувьтай байна.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

АУДИТЫН КОД: ДОО-2025/06-09-ШТА-НА

Чойбалсан хот
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Я.Зориг
Утас: 7058-4204, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4204, Цахим хаяг: enkhbaatars@audit.gov.mn
Аудитор М.Ганбилэг
Утас: 7058-4204, Цахим хаяг: ganbilegm@audit.gov.mn
Аудитор Ч.Удвалноров
Утас: 7058-4204, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёг.....	4
Дүрслэлийн товъёг.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ.....6**БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд хууль, журамд заасан төлөвлөлтийн шаардлагад бүрэн нийцэхгүй байна.....7**

1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичигтэй уялдсан байна.....7

1.2. Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр шинээр 2 төсөл, арга хэмжээ нэмэгдэж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд урсгал зардлын тооцоолол, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлт гаргах, төсөл, арга хэмжээг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх ажлыг хууль, журамд заасны дагуу зохион байгуулаагүй байна.....7-9

1.3 Төрийн хэмнэлтийн тухай хуульд төсөл, арга хэмжээг 96.3 хувийн биелэлттэй нийцүүлэн төлөвлөсөн ба тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих төсөл арга хэмжээний биелэлт 94.1 хувьтай төлөвлөгдсөн байна.....10

БҮЛЭГ 2. Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 35.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.....11

2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулах өөрчлөлт, тендер шалгаруулалтын аргыг сонгох ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.....11-12

2.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулсан байна.....12

2.3. Худалдан авах ажиллагаанд тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангаагүй гүйцэтгэчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан 1 төсөл, арга хэмжээ байна.....12-13

БҮЛЭГ 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлсэн ч 1 төсөл, арга хэмжээг данс бүртгэлд 145.4 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.....14

3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль, журмын дагуу санхүүжүүлсэн байна.....14

3.2 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаандаа хэрэгжүүлж, гэрээг дүгнэсэн байна.....14

3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 948.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй, 240.1 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг чанаргүй гүйцэтгэсэн зөрчил илэрч байна.....14-15

3.4. Хэрэгжиж дууссан 172.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 ажлыг данс бүртгэлд 145.4 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.....16

ДҮГНЭЛТ:.....17-18

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:.....19

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:.....20

ЗӨВЛӨМЖ:.....20-21

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....22

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ:.....23-24

Товчилсон үгийн тайлбар

ДОА	Дорнод аймаг
ДОАОНӨГ	Дорнод аймаг Орон нутгийн өмчийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НА	Нийцлийн аудит
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХА	Харьцуулалтын арга
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТА	Шууд тайлагналын аудит
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
MNS	Mongolian national standard

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	“Төсвийн тодотгоолоор санхүүжих дүн, төсөвт өртөг өөрчлөгдсөн ТАХ-мян.төг”	7
Хүснэгт 2	Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл, арга хэмжээ	9
Хүснэгт 3	Тендер шалгаруулалтын арга	10
Хүснэгт 4	Батлагдсан зураг, төсвөөс зөрүүтэй хийгдсэн ТАХ	14

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	“ТАХ-ний гүйцэтгэл”	6
Хүснэгт 2	“ТАХ-ний ангилал”	6
Хүснэгт 3	“Хөрөнгө оруулалт хийгдсэн салбар – ТАХ-ний тоогоор”	6

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/107 дугаар тушаалыг үндэслэн хийнэ.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх • Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитад Дорнод аймагт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ болон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, сумдын Засаг дарга нар, захиалагч байгууллагууд, хяналт хэрэгжүүлсэн байгууллагууд, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудит хийлээ.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, дүн шинжилгээ, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэв.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Я.Зориг, аудитор С.Энхбаатар, М.Ганбилэг, Ч.Удвалноров нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.</p> <p>Аудитын талбарын ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж, тайланг 05 дугаар сарын 23-ны өдөр Нийслэл дэх Төрийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.</p>

ТАХ-НИЙ ХЭРЭГЖИЛТ

Орон нутгийн төсвийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт шинээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хувьд 97 хувьтай, он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний хувьд 51.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дорнод аймгийн орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шилжих 853.7 сая төгрөгийн төсөвт 5 төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжүүлэх 10,337.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Үүнээс 2023-2024 он дамжин хэрэгжсэн ажлын гүйцэтгэл 100 хувь, 2024 онд шинээр хэрэгжсэн ажлын гүйцэтгэл 97 хувь, 2024-2025 он дамжин хэрэгжих ажлын гүйцэтгэл 51.1 хувийн хэрэгжилттэй байна. Гэрээний хэрэгжилтээр тайлант онд хэрэгжиж дууссан 20, хэрэгжээгүй 1, хэрэгжилт дутуу буюу он дамжин хэрэгжих 6 төсөл, арга хэмжээ байна.

Тайлант онд нийт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ангиллын хувьд барилга, байгууламж 11 хувь, их засвар, тохижилт 48 хувь, тоног төхөөмж 41 хувийг эзэлж байна. Үүнээс боловсрол, соёлын салбарт 33 хувь, орон нутгийн төсөвт байгууллагад 30 хувь, улсын төсвийн байгууллагад 22 хувь, эрүүл мэндийн салбарт 7 хувь, гамшгаас хамгаалах салбарт 4 хувь, Төрийн бус байгууллагад 4 хувийн хөрөнгө оруулалтын ажил хийгджээ.


Дүрслэл 1. "ТАХ-ний гүйцэтгэл"



Дүрслэл 2. "ТАХ-ний ангилал"



Дүрслэл 3. "Хөрөнгө оруулалт хийгдсэн салбар – ТАХ-ний тоогоор"



БҮЛЭГ 1

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд хууль, журамд заасан төлөвлөлтийн шаардлагад бүрэн нийцэхгүй байна.

1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичигтэй уялдсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 27 төсөл, арга хэмжээг шинээр төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг шалгахад Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Дорнод аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дорнод аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө зэрэг хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн төлөвлөсөн байна.

Эдгээр хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд нь “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

1.2. Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр шинээр 2 төсөл, арга хэмжээ нэмэгдэж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд урсгал зардлын тооцоолол, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлт гаргах, төсөл, арга хэмжээг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх ажлыг хууль, журамд заасны дагуу зохион байгуулаагүй байна.

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6.в.¹-д хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлагыг хангасан байх, 29.2², 29¹.2.4³-т хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргах талаар заажээ.

Аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төслийг боловсруулахдаа шинээр бий болох барилга байгууламжийн урсгал зардал, холбогдох тооцоог хавсаргаагүй, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлтийг гаргаагүй байна. Тухайлбал “Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих” ажлын цаашид гарах урсгал зардлыг тооцож үзээгүй байна. Мөн барилгын гаднах инженерийн байгууламжийн төсвийг батлагдсан төсөвтэй хамт иж бүрнээр нь батлаагүйгээс төсөл, арга хэмжээ зорилтот үр дүндээ хүрэхгүй байх, он дамжих зэрэг нөхцөл

¹ 6.2.6.в. Засгийн газар, Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөл дэх төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хамаарах өөрчлөлт нь энэ хуульд заасан төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлагыг хангасан байх.

² 29.2. Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

³ 29¹.2.4. урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх;

байдал үүссэн байна. /Аудитын дүгнэлтийг үндэслэн тухайн асуудалд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв./

2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.6⁴, 42 дугаар зүйлийн 42.7⁵-д зааснаар тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулсан, шинээр нэмж баталсан дараах төсөл, арга хэмжээнүүд байна. Үүнд:

Хүснэгт №1. "Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр төсөвт өртөг өөрчлөгдсөн ТАХ-мян.төг"

№	Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөвт өртөг /2023-19/11 тогтоол/	Өөрчлөгдсөн дүн /2024-22/01 тогтоол/	Өөрчлөгдсөн дүн /2024-02/02 тогтоол/	Зөрүү өөрчлөлт (нэмсэн, хассан)
Шинэ төсөл, арга хэмжээ					
1	Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн засвар, тохижилт	-	97,826.8	127,826.8	30,000.0
2	Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн халаалтын систем, гадна, дотор инженерийн шугам сүлжээний их засвар, шинэчлэлт	-	83,096.5	-	-
	НИЙТ		180,923.3	127,826.8	30,000.0
Төсөвт өртөг, санхүүжих дүнг бууруулсан төсөл арга хэмжээ					
1	Төрийн тусгай болон хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж байгаа албан хаагчдад гэрээгээр ашиглуулах 3 орон сууц худалдан авах	360,000.0	140,000.0	-	(220,000.0)
2	Нутгийн удирдлагын байрны барилгын дотоод тохижилт, тоног төхөөрөмж	257,197.6	134,997.0	-	(122,200.6)
3	Төрийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмж	71,740.0	34,340.0	-	(37,400.0)
4	Гамшгаас хамгаалах, Цагдаагийн албаны бэлэн байдлыг хангахад шаардлагатай авто машин (Зүүн бүсийн төв Дорнод аймаг дахь Онцгой байдлын газар, Цагдаагийн газар)	190,000.0	70,000.0	-	(120,000.0)
	НИЙТ	878,937.6	379,337.0		(499,600.6)

Эх үүсвэр: "ИТХ-ын 2023 оны 19/11, 2024 оны 22/01, 02/02 дугаар тогтоол

Орон нутгийн төсвийн 2024 оны 2 удаагийн нэмэлт өөрчлөлтөөр 4 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 499.6 сая төгрөгөөр, санхүүжих дүнг 373.6 сая төгрөгөөр бууруулж, шинээр 180.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээг нэмж баталсан нь төсвийн тухай хуулийн 29.3.6, 42.7 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

⁴ 29.3.6. тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх.

⁵ 42.7.Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

Энэ нь нэгдүгээрт төсвийн орлогын төлөвлөгөө биелээгүй, хоёрдугаарт төсөл, арга хэмжээ шинээр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. /Аудитын дүгнэлтийг үндэслэн тухайн асуудалд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв./

3. Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.16}, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2⁷-ын 2.2.1⁸, 2.2.2⁹-т зааснаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, судалгаа хийгдсэн, холбогдох шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлэн нэн тэргүүний ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг жагсаалтад тусгах талаар заасан байна.

Гэтэл орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заасан 6 үзүүлэлт бүхий шалгуурын дагуу тэргүүлэх ач холбогдлоор нь судлан үнэлж, эрэмбэлэх ажлыг зохион байгуулаагүй байна. Харин хөрөнгө оруулалтын ажлын хэсгээр хуралдаж төсөл, арга хэмжээний жагсаалтыг боловсруулсан байна. /Аудитын дүгнэлтийг үндэслэн тухайн асуудалд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв./

4. Төсвийн тухай хуулийн 29^{1.210}-ын 29^{1.2.111}, 29^{1.2.212}, 29^{1.2.613}-д хэрэгжих төсөл, арга хэмжээ нь газрын болон бусад зөвшөөрлийг авсан байх, магадлалаар баталгаажсан төсөвтэй байх, олон нийтээр хэлэлцүүлсэн байх зэрэг төлөвлөлтийн шаардлага хангасан байх талаар заажээ. Гэтэл газрын зөвшөөрөл нь олгогдсон боловч төлөвлөсөн газраасаа өөр бусад байгууллагын газарт баригдаж байгаа дараах барилга, байгууламжууд байна. Үүнд:

- Баяндун суманд баригдаж байгаа төрийн албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууц нь төлөвлөсөн газраа өөрчилж, инженерийн байгууламж, дэд бүтцийн асуудлаас шалтгаалан төрийн өмчийн эмнэлгийн газар дээр баригдаж байна. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна.
- Баянтүмэн суманд баригдаж байгаа төрийн албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууц нь анхны төлөвлөсөн газраа өөрчилж, инженерийн байгууламж, дэд бүтцийн асуудлаас шалтгаалан Соёлын төвийн газар дээр баригдаж байна. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна.
- Булган суманд баригдаж байгаа төрийн албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууц нь газрын зөвшөөрлийн баримт бичиггүй төлөвлөгдөж, 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Харин 2024 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтад төвөгшил өндөртэй, магадлалаар баталгаажуулах шаардлагатай барилга, байгууламжийн ажил

⁶ 29^{1.1}. Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.

⁷ 2.2. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

⁸ 2.2.1. Төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэн, эрэмбэлэх, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тогтоох;

⁹ 2.2.2. Төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах;

¹⁰ 29^{1.2}. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх:

¹¹ 29^{1.2.1}. тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;

¹² 29^{1.2.2}. барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

¹³ 29^{1.2.6}. олон нийтээр хэлэлцүүлсэн байх.

тусгагдаагүй байна. Төсөл, арга хэмжээнүүдийг аймгийн 14 сумдын иргэдээс санал авч төлөвлөсөн байна. /Аудитын дүгнэлтийг үндэслэн газрын зөвшөөрөлтэй холбоотой асуудалд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв./

1.3 Төрийн хэмнэлтийн тухай хуульд төсөл, арга хэмжээг 96.3 хувийн биелэлттэй нийцүүлэн төлөвлөсөн ба тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих төсөл арга хэмжээний биелэлт 94.1 хувьтай төлөвлөгдсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчит барилга, байгууламжийн засвар, тохижилт төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 30.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр нэмэгдүүлэх саналыг захиалагчаас гаргаж, энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх,” гэж заасантай нийцэхгүй байна. /Аудитын дүгнэлтийг үндэслэн зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв./

Түүнчлэн орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй нийт 597.1 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байгаа нь 2024 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын нийт зардлын 5.9 хувийг эзэлж байна. /Хүснэгт 2-т харуулав./

Хүснэгт 2. “Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл, арга хэмжээ”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мянган төгрөг/
1	Төрийн тусгай болон хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж байгаа албан хаагчдад гэрээгээр ашиглуулах 3 орон сууц худалдан авах	140,000.0
2	Ахмадын байгууллагад хэрэгцээтэй компьютер, тоног төхөөрөмж	29,800.0
3	Нутгийн удирдлагын байрны барилгын дотоод тохижилт, тоног төхөөрөмж	134,997.0
4	Төрийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмж	34,340.0
5	Төрийн тусгай чиг үүргийн болон төрийн байгууллагын албан хэрэгцээнд авто машин (Сүмбэрийн 0198-р анги, ШШГА-ны машин)	220,000.0
6	Лабораторийн тоног төхөөрөмж	38,000.0
Нийт дүн		597,137.0

Эх сурвалж: Төсөл, арга хэмжээний нэгдсэн судалгаа

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ”, 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.6.6 дахь “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. /Аудитын дүгнэлтийг үндэслэн тухайн асуудалд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв./

БҮЛЭГ 2

Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 35.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулах өөрчлөлт, тендер шалгаруулалтын аргыг сонгох ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6¹⁴-ийн 6.6.3¹⁵, 14 дүгээр зүйлийн 14.4¹⁶, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1¹⁷-ийн -д 4.1.1¹⁸-д хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг төсвийн төвлөрүүлэн, төсвийн шууд захирагч нарт шилжүүлэх талаар заасан байна. Тайлант хугацаанд буюу 2024 онд төсвийн ерөнхийлөн захирагчаас бусад төсөв захирагч нарт төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн тохиолдол гараагүй байна.

2. Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.11¹⁹, Сангийн Сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.5²⁰-д худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг тусган батлах талаар заасан. Гэтэл аймгийн орон нутгийн 2024 оны төсөвт 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулж, төсвийн зохицуулалтаар шинээр 2 төсөл, арга хэмжээ нэмэгдэж, 5 төсөл, арга хэмжээг бусад эх үүсвэр рүү шилжүүлэн хасаж, 5 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнд өөрчлөлт оруулжээ.

Харин ТЕЗ-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж, батлаагүй байна. /Аудитын дүгнэлтийг үндэслэн тухайн асуудалд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв./

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлд тендер шалгаруулалтын аргыг хэрэглэх талаар заасан байна. ТЕЗ-ийн 2024 худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж баталсныг өөрчилж худалдан авах ажиллагаа зарласан дараах ажлууд байна. Үүнд:

¹⁴ 6.6. Энэ хуулийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

¹⁵ 6.6.3. төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх;

¹⁶ 14.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

¹⁷ 4.1. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэх:

¹⁸ 4.1.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна:

¹⁹ 2.11.Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна.

²⁰ 3.1.5.Тухайн төсвийн захирагчийн үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөтэй нягт уялдсан байх;

Хүснэгт 3. “Тендер шалгаруулалтын арга”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян.төг/	Тендер шалгаруулалтын арга		Тайлбар
			Анх төлөвлөсөн	ХАА зарласан	
1	Цэцэрлэгийн барилгын засвар (10 дугаар цэцэрлэг)	77.8	ХА	НТШ	ХАА-ны аргыг буруу ашигласан байна.
2	Соёлын төвд хөгжим, тоног төхөөрөмж (Гурванзагал, Дашбалбар, Хөлөнбуйр сумд)	53.0	ХА	НТШ	
3	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Иргэний танхимын тохижилт, тоног төхөөрөмж	63.1	ХА	НТШ	
4	Лабораторийн тоног төхөөрөмж (Шүүх шинжилгээний хэлтэс)	38.0	ХА	НТШ	
	НИЙТ	231.8			

Эх үүсвэр: ТЕЗ-ийн 2024 оны ХАА-ны төлөвлөгөө, ХАА-ны тайлан

/Аудитын дүгнэлтийг үндэслэн тухайн асуудалд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв./

2.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.” гэж заажээ. Харин Сангийн Сайдын холбогдох тушаалаар тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг шинэчлэн батлагдсан байна.

Аймгийн орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороод нь тендерийн баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТ хууль болон Сангийн Сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу боловсруулж, батлуулсан байна.

2.3. Худалдан авах ажиллагаанд тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан 1 төсөл, арга хэмжээ байна.

1. Дорнод аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд 72.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих үзэсгэлэн худалдаа, уралдаан тэмцээн зохион байгуулахад шаардлагатай бараа” /ДОАОНӨГ/202412029/-г 2 багц болгон нээлттэй тендер шалгаруулалт зарласан байна. 1-р багц буюу 35.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Үндэсний бөхийн барилдаанд ашиглах дэвжээ” худалдан авах нээлттэй тендер “Талын сүлд” ХХК /35,000,000 төгрөг/, “Цэс ус” ХХК /20,680,000 төгрөг/ оролцсон байна. Тус тендерийн баримт бичигт ТШЗ 20.1-т туршлагын мэдээллийг дараах байдлаар гарган ирүүлнэ. Үүнд:

1. Маягт3, “Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл”

2. Маягт4, “Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл”-ийг шаардана гэж заасан байна.

Мөн хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний талаарх мэдээллийн маягт4, “Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл”-ийн дагуу ирүүлэх талаар заасан боловч тендерт шалгарсан “Талын сүлд” ХХК дээрх мэдээллүүдийг маягтын дагуу ирүүлээгүй байхад гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 “Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт”, 17.2.2.”Бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт”, 28 дугаар зүйлийн 28.1.3 “шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзах” гэх хуулийн заалтуудтай нийцэхгүй байна. /Аудитын дүгнэлтийг үндэслэн тухайн асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв./

2. “Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн халаалтын систем, гадна, дотно инженерийн шугам сүлжээний их засвар, шинэчлэлт” төсөл арга хэмжээний 1-р багц буюу 9,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй “Усан хангамжийн худгийн насос засварлах”, 2-р багц буюу 20,067,353 төгрөгийн төсөвт өртөгтэй Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн халаалтын систем, гадна, дотно инженерийн шугам сүлжээ” гэх тендерт нэг хуулийн этгээдээс тендерийн баримт бичиг ирүүлсэн байна. Тендерийн баримт бичиг ирүүлсэн “Элтрүүд” ХХК нь хууль, журамд заасан шаардлагад нийцэж 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 1/1272 дугаар “Гэрээ байгуулах эрх олгох тухай” албан бичиг хүргүүлсэн боловч гэрээ байгуулаагүй, гэрээ байгуулах эсэхтэй холбоотой ямар нэгэн хариу өгөөгүй байна. Гэрээ байгуулаагүйгээс шалтгаалан төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, зорилтот үр дүндээ хүрээгүй байна. /Аудитын дүгнэлтийг үндэслэн тухайн асуудалд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв./

БҮЛЭГ 3

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлсэн ч 1 төсөл, арга хэмжээг данс бүртгэлд 145.4 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.

3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль, журмын дагуу санхүүжүүлсэн байна.

Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д орон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгох талаар зохицуулжээ.

Хөрөнгө оруулалтын шинээр хэрэгжих 27 төсөл, арга хэмжээнээс 26 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэл, төсөл, арга хэмжээг хүлээн авах комиссын акт, дүгнэлт, гэрээ дүгнэсэн шийдвэр зэргийг үндэслэн холбогдох хууль журмын дагуу санхүүжүүлсэн байна.

3.2 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаандаа хэрэгжүүлж, гэрээг дүгнэсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр төлөвлөн хэрэгжүүлсэн нийт 10,337.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээний 6,614.6 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ он дамжин хийхээр төлөвлөж, тус онд 2,055.4 сая төгрөгийг санхүүжилтийг олгосон байна.

Тус онд шинээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаандаа хэрэгжүүлж, гэрээг дүгнэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;" гэж заасантай нийцэж байна.

3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 948.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй, 240.1 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг чанаргүй гүйцэтгэсэн зөрчил илэрч байна.

1. Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хийгээгүйгээс батлагдсан зураг, төсвөөс зөрүүтэй, ашиглалтын явцад эвдрэл гэмтэл үүссэн зөрчлүүд гарсан байна.

Батлагдсан зураг, төсвөөс зөрүүтэй гүйцэтгэсэн 948.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 4 “Батлагдсан зураг, төсвөөс зөрүүтэй хийгдсэн ТАХ”

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Гүйцэтгэгчийн нэр	Шалтгаан тайлбар
1	“Чойбалсан сумын ЭМТ-ийн барилгын Б блокийн засвар”	229.6	“Баянлуу” ХХК	Ажлын зураг, төсөвт дотоод заслын засварын ажилд таазанд модон карказ зангидаж гипсэн хавтангаар гоёлын тааз угсрах /амрах өрөө, коридор/ байсныг тус ЭМТ-ийн дарга гүйцэтгэгч компанитай тохиролцож, зурагт өөрчлөлт оруулж вакуум хаалтыг хийлгэсэн байна. Энэ талаар гүйцэтгэгч компанитай хийсэн хурлын тэмдэглэл, хүсэлт, албан бичиг байхгүй байна.
2	Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих /багц 4/ Чойбалсан сум	718.4	“Тосон Мөрөн” ХХК	Ажлын зураг, төсөвт зоорийн ажил тусгагдаагүй боловч гүйцэтгэгч компани зурагт өөрчлөлт оруулан зоорийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Гүйцэтгэгч компани уг зоорийн ажлыг өөрийн хөрөнгөөр хийнэ гэж захиалагчтай тохиролцсон байна. Энэ талаар зохиогчийн хяналтын тайланд тусгаагүй, хурлын тэмдэглэл, албан бичгээр өгсөн хүсэлт зэрэг нотлох баримт байхгүй байна.
НИЙТ		948.0		

Эх сурвалж: Аудиторын ажлын баримт

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 “Захиалагч барилга байгууламжийн зураг төслийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.” гэх заалтыг зөрчсөн байна.

Дээрх зөрчил нь зураг төсвийг ашиглагч байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцүүлж боловсруулаагүй, төлөвлөлтийн алдаатай холбон тайлбарлаж болох бөгөөд гүйцэтгэлийн явцад зураг, төсөвт өөрчлөлт орж байгаад захиалагч, зохиогчийн зүгээс зохих шаардлагыг тавьж, шийдвэрлэхгүй байгаатай холбоотой байна. /Аудитын дүгнэлтийг үндэслэн тухайн асуудалд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв./

2. Ашиглалтын явцад эвдрэл гэмтэл, доголдол үүссэн 1 төсөл арга хэмжээ байгаа нь 240.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дорнын мөнгөн хийц” ХХК-ийн гүйцэтгэсэн “Чойбалсан сумын ЕБС-ийн спорт заалны барилгын засвар”-ын ажил байна. Тус төсөл, арга хэмжээ нь ашиглалтын явцад тааз болон ханаар ус гоожиж, нэвчсэн, будаг ховхорч, хуурсан, дээврийн хашлага ханын дээд талд цайрдсан төмөр эдлэлүүд чанаргүй хийгдсэн, хуйлмал ба ширхгийн материалаар бүрсэн дээвэрт хар цаасны захыг туузан төмөр /40x4мм/-өөр дарж хадаагүй, барилгын гадна талын төмөр эдлэл болон ус зайлуулах хоолой хийгээгүй, орох, гарах хөдөлгөөний заасан гэрэлтүүлэгч хагарсан /2 ширхэг/ байдалтай байна.

/Аудитын дүгнэлтийг үндэслэн ашиглалтын шаардлагад нийцүүлж, доголдол үүссэн асуудлуудыг дахин засварлуулах талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв./



“Чойбалсан сумын ЕБС-ын спорт заалны барилгын засварын ажил чанаргүй хийгдсэн байна.”

3.4. Хэрэгжиж дууссан 172.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 ажлыг данс бүртгэлд 145.4 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг бүртгэх, ашиглуулах талаар заажээ.

Аймгийн орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээнүүдээс 172.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй "Онцгой байдлын үед хэрэглэх хадлан, өвс тэжээлийн агуулах барих" (АДАПТ төсөл- 70%, аймаг-15%, Дашбалбар, Халхгол сумд-15%) Багц 2” ажлыг Халхгол сумын ЗДТГ бүртгэлд тусгасан боловч 145.4 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.

Харин хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийг ашиглагч байгууллагууд зориулалтын дагуу ашиглаж байна. /Аудитын дүгнэлтийг үндэслэн тухайн асуудалд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв./

ДҮГНЭЛТ

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорил, цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлттэй холбоотой:

1. Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд нь улс, аймгийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаж, хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

2. Сумдад баригдах 8 айлын орон сууцны урсгал зардал, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлтийг тооцож үзээгүй, төсөл, арга хэмжээнүүдийг тэргүүлэх ач холбогдлоор нь судлан үнэлж, эрэмбэлэх ажлыг зохион байгуулаагүй нь хууль, журмыг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна. Барилгын гаднах инженерийн байгууламжийн зураг төсвийг үндсэн барилгын зураг, төсөвтэй иж бүрэн байдлаар төлөвлөөгүйгээс шалтгаалан төсөл, арга хэмжээ зорилтот үр дүндээ хүрэхгүй байх, он дамжин хэрэгжих эрсдэлийг үүсгэж байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны 2 удаагийн нэмэлт өөрчлөлтөөр 4 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 499.6 сая төгрөгөөр, санхүүжих дүнг 373.6 сая төгрөгөөр бууруулж, шинээр 180.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээг нэмж баталсан нь төсвийн тухай хуулийн 29.3.6, 42.7 дахь санхүүжих дүнг бууруулахгүй байх, төсөвт зохицуулалт хийх заалтуудтай нийцэхгүй байна.

Баяндун, Баянтүмэн, Булган сумдад баригдаж байгаа 8 айлын орон сууцны барилгын газрын зөвшөөрөл нь олгогдсон боловч төлөвлөсөн газраасаа өөр бусад байгууллагын эзэмшил газарт барилга, байгууламжийг барьж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн нь төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангахгүй байна.

3. Тайлант онд хэрэгжих 97.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн засвар, тохижилт”-ын ажлыг 30.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр нэмэгдүүлж баталсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтыг баримтлаагүй байна. Түүнчлэн орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй нийт 597.1 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг /Хүснэгт 2-т заасан/ төлөвлөж хэрэгжүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, 6.4.1, 6.6.6 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

4. Орон нутгийн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах зохицуулалтаар ТАХ-г нэмж, 5 ТАХ- хасаж, 5 ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүнд өөрчлөлт оруулсан боловч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусгаж батлаагүй, ХАА-ны төлөвлөгөөнд 231.8 сая төгрөгийн 5 ТАХ-г харьцуулалтын аргаар зохион байгуулахаар төлөвлөсөн боловч тус ажлуудыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан нь Сангийн сайдын баталсан журмуудыг баримталж ажиллаагүйтэй холбоотой байна.

Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой:

5. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороод нь тендерийн баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТ хууль болон Сангийн Сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу боловсруулж, батлуулсан байна.

6. “Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих үзэсгэлэн худалдаа, уралдаан тэмцээн зохион байгуулахад шаардлагатай бараа” нэртэй тендерийг зохион байгуулахдаа оролцогчоос хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний талаарх мэдээллийг маягт-4-өөр, “Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл”-ийн дагуу ирүүлэх талаар заасан боловч тендерт шалгарсан “Талын сүлд” ХХК дээрх мэдээллүүдийг маягтын дагуу ирүүлээгүй байхад гэрээ байгуулсан байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн халаалтын систем, гадна, дотно инженерийн шугам сүлжээний их засвар, шинэчлэлт” төсөл арга хэмжээний 1, 2-р багцад шалгарсан “Элтрүүд” ХХК-иас гэрээ байгуулаагүйгээс тус ажил нь хэрэгжээгүй байна.

7. Хөрөнгө оруулалтын шинээр хэрэгжсэн 26 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгоходоо ажлын гүйцэтгэл, төсөл, арга хэмжээг хүлээн авах комиссын акт, дүгнэлт, гэрээ дүгнэсэн шийдвэр зэргийг үндэслэн холбогдох хууль журмын дагуу санхүүжүүлсэн байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилттэй холбоотой:



8. Тайлант хугацаанд төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаандаа хэрэгжүүлж, гэрээг дүгнэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь заалттай нийцэж байна.

9. Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг чанартай хийгээгүйгээс шалтгаалан батлагдсан зураг, төсвөөс зөрүүтэй 948.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ байна. Тус зөрчлүүд нь зураг төсвийг ашиглагч байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцүүлж боловсруулаагүй, төлөвлөлтийн алдаатай холбон тайлбарлаж болох бөгөөд гүйцэтгэлийн явцад зураг, төсөвт өөрчлөлт орж байгаад захиалагч, зохиогчийн зүгээс зохих шаардлагыг тавьж, шийдвэрлэхгүй байгаатай холбоотой байна.

Ашиглалтын явцад эвдрэл гэмтэл, доголдол үүссэн 240.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээ байна.

10. Халхгол суманд баригдсан "Онцгой байдлын үед хэрэглэх хадлан, өвс тэжээлийн агуулах барих" ажлыг данс бүртгэлд тусгасан боловч 145.4 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:

 <p>МОНГОЛ УЛС ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА</p> <p>Бэлтгэгчийн гүйцэтгэл, 9 дугаар баг Хөдөлгөөний сүлжээний алба, 21002 Утас: 7058-4202, факс: 7058-4384 Цахим хуудас: zasa@mongol.gov.mn Цахим хуудас: Dornod.gov.mn</p> <p>2025.05.23 № 1/201 Тайлбар хүргүүлэх тухай</p>	<p>ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА</p> <p>Я.Зүрмис Төрийн аудитын газрын дарга Дундуг урьдчилсан хяналт</p> <p>2</p> <p>Эзгэгч алхмуудыг хийх боломжгүй байсан бөгөөд 2024 оны эхээр бүх аймгууд дээрх нөхцөл байдалд байсан болно. Энэ асуудлаар төрийн Худалдан авах ажиллагааны газраас лавлагаа гаргуулан авч өгөх боломжтой. Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс болон Худалдан авах ажиллагааны газраас төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж ажиллахыг эрмэлзэж ажилладаг. Төлөвлөлтийн дагуу зарлаагүй гэх 4 төсөл, арга хэмжээ нь харьцуулалтын аргаар буюу ажлын 5 хоног зарлахаар төлөвлөгөөнд тусгасан байсныг ажлын 15 хоног зарласан нь ажлын гүйцэтгэлийг шалгаруулах, хэрэгжих хугацааг удаашруулах нөхцөл болсон. Энэ нь Худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагаатай холбоотой гэхээс илүү хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор цахим системд хийгдсэн шинэчлэлттэй шууд холбоотой юм.</p> <p>4.Төндөрийн баримт бичгийн шаардлага хангаагүй, өндөр үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгжийг шалгаруулсан гэх асуудалд; Тухайн төсөл, арга хэмжээ нь үндэсний бөхийн барилдаанд ашиглах ногоон хивс худалдан авсан. Захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтоор дотоодод үйлдвэрлэсэн бараа байхаар заасан бөгөөд санал ирүүлсэн 2 аж ахуйн нэгжийн нэг нь БНХАУ-д үйлдвэрлэсэн хивсийг хямд үнээр санал болгосон, эрх олгосон компани нь Эрдэнэт үйлдвэрийн дэвжээний зориулалттай хивсийг батлагдсан төсөвт багтаан санал ирүүлсэн тул үнэлгээний хорооны олонхын саналаар шалгаруулсан. Мөн тухайн барааг сар шинийн баярын барилдаанд ашиглахаар төлөвлөж байсан бөгөөд худалдан авах ажиллагаа сар шинийн баяртай хугацааны хувьд тулгуур нэгдсэн тул эрх олгох ажлыг захиалагчид хүргүүлсэн.</p> <p>5.Цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын ажлыг зураг, төсөв (түлхүү нийгмийн салбарын барилга байгууламж)-ийг боловсруулахдаа ашиглагч байгууллагын саналыг тусгаж ажиллахаас гадна эдийн засаг болоод нийгмийн үр өгөөж бүхий төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэн хэрэгжүүлж ажиллана.</p> <p>Хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх шатандаа төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно.</p> <p>Орлогч:  ТАНБАТ</p>
---	--

2125060770

Саналд өгсөн тайлбар:

1. Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний гүйцэтгэл, он дамжуулан гүйцэтгэх ажлын нийт гүйцэтгэлийг үнэлж, дүгнэлтэд өөрчлөлтийг тусгав.
2. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.6.6 дахь заалтуудтай холбоотой асуудалд нэгдсэн тайланд тусгах саналыг хүргүүлэхээр шийдвэрлэв.
3. ХАА-ны аргын ашиглалтын талаар өгсөн тайлбарт үнэлэлт, дүгнэлт өгсний дүнд зөвлөмжийг хэвээр үлдээхээр шийдвэрлэв.
4. Аудитын шийдвэрт өгсөн тайлбар, ХАА-ны явцад гарсан гомдол, түүний шийдвэрлэлт, худалдан авах ажиллагааны дүнд үзүүлэх нөлөөллийг үнэлж, дүгнэн шийдвэрт өөрчлөлт оруулан албан шаардлага болгож өөрчлөлтийг тайланд тусгав.
5. Тайлбарыг үнэлж, зөвлөмжийг тайланд хэвээр тусгахаар шийдвэрлэв.

УАГ-ААР ДАМЖУУЛАН ХОЛБОГДОХ ГАЗРУУДАД УЛАМЖЛАХ САНАЛ:

1. Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-ын “Засаг дарга, хот, тосгоны Захирагч дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлнэ.” 34.2.1, 34.2.2, 34.2.3 дахь хэсэгт орон нутгийн тухайн жилийн төсөвт тодотгол хийх болсон тухай нөхцөл шаардлагыг тусгасан байдаг.

Гэтэл 2024 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн засвар, тохижилтын ажлыг хийх хэрэгцээ шаардлага үүссэний улмаас “Аймгийн 2024 оны төсөвт зохицуулалт оруулах тухай” нэрээр ИТХ-аар хэлэлцүүлэн тогтоол гаргуулан баталсан байна. Ингэхдээ 2024 оны төсвийн нийт дүнд өөрчлөлт оруулахгүйгээр хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээнүүдийн төсөвт өртгийг бууруулан шинээр төсөл, арга хэмжээг нэмж баталсан байна. Энэ асуудлыг төсөвт зохицуулалт хийсэн гэж үзвэл Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7 дахь “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгаадаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.” гэсэн заалттай нийцэхгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хуучны барилгуудад засвар, үйлчилгээ хийх зайлшгүй шаардлага үүсэхэд аймгийн Засаг дарга нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд шинээр төсөл, арга хэмжээг нэмж батлах, төсөвт зохицуулалт хийх талаар хуулийн зохицуулалт байхгүй. Нөгөө талаас энэ асуудал нь төсөвт тодотгол хийх урьдчилсан нөхцөл байдалд хамаарахгүй, төсөвт өөрчлөлт оруулах тухай тогтоол гаргаж байгаа нь хуулиар зохицуулагдаагүй асуудал болоод байна.

Иймд энэ асуудлыг хууль тогтоомжид нарийвчлан тусгаж, зохицуулах шаардлага үүсэж байгаа тул нэгдсэн тайланд тусгуулах саналтай байна.

2. Босоо удирдлагатай буюу төрийн өмчит байгууллагуудад шилжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг орон нутгийн төсөвт төлөвлөж, хэрэгжүүлэх байдал нийтлэг гарч байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байх тул төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн бие даасан байдлыг бэхжүүлэх бодлогыг нэгдсэн тайланд тусгуулах саналтай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах төсөв захирагч нарт зөвлөж байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын дарга Г.Цолмонд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтыг баримтлан төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнд хурлаар нэмэгдүүлэхгүй байх, энэ талаар ИТХ-ын төлөөлөгч нарт хуулийн зүйл заалтыг таниулах ажлыг зохион байгуулах.

2. Тухайн жилийн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал нь Төсвийн тухай хууль болон бусад хуулиар зохицуулагдаагүй тул төсвийн тодотгол хийхээс бусад тохиолдолд төсөвт нэмэлт өөрчлөлт оруулахгүй байх.

3. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.6.6 дахь заалтыг баримтлан цаашид орон нутгийн төсвийн байгууллагаас бусад байгууллага болох босоо удирдлагатай, төрийн өмчийн байгууллагуудад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хуваарилж, батлахгүй байх.

1. Аймгийн Засаг дарга Ш.Ёлд:

1. Цаашид төсөл, арга хэмжээний жагсаалтыг боловсруулахдаа Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.2.4-т заасан хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардлын тооцоо, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлтийг гаргах.

2. Төсвийн тухай хуулийн 29¹.2.1-д заасан газрын зөвшөөрөл болон бусад зөвшөөрлийг авах, төлөвлөсөн газарт барилга байгууламжийг барих зэрэг төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлуулах.

3. Сангийн Сайдын 2023 оны А/250 дугаар тогтоолын 2.11 дэх заалтыг баримтлан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулж, өөрчлөлтийг тухай бүр тусгаж батлах.

4. Хууль, журамд заасныг баримтлан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан тендер шалгаруулалтын аргыг зөв сонгож худалдан авах ажиллагааг зохион байгуулах.

5. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй хуулийн хугацаанд гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, ТББ-т заасан гэрээ байгуулах хугацаанаас хэтэрсэн тохиолдолд худалдан авах ажиллагааг дахин зарлаж, төсөл, арга хэмжээг тайлант онд хэрэгжүүлж дуусгах.

Аудитаар нийт 2,838.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 2,547.2 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 290.9 сая төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өгч, Үндэсний аудитын газарт 2 саналыг уламжиллаа.

Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Анхаарах зүйл: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг **аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор** төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



2025 оны 05 сарын 23 өдөр

Дарга /Б.Болортуул/

Чайрхайн 407

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Нийслэл дэх төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон аудитад хамрагдсан бусад байгууллагад тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Я.Зориг)-т даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

2125010035

Дарга, Тэргүүлэх аудиторын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 1/20 дүгээр тушаалын хавсралт

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр, албан тушаал	Нийцлийн аудитын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлагын утга	Мөнгөн дүн /гөгрөгөөр/
1.	Халхгол сумын ЗДТГ	ДОА-2025/21-9-ШТА-НА	Зөрчил арилгах тухай /данс бүртгэл/	172,415,363
2.	Аймгийн Засаг дарга		Зөрчил арилгах тухай /гөлөөлөлт/	554,500,000
3.	Аймгийн Засаг дарга		Зөрчил арилгах тухай /чиг үүрэг/	597,137,000
4.	Аймгийн Засаг дарга		Зөрчил арилгах тухай /чанаргүй ТАХ/	240,112,100
5.	Аймгийн Засаг дарга		Зөрчил арилгах тухай /зураг төсөв/	948,058,525
6.	Аймгийн Засаг дарга		Зөрчил арилгах тухай /ХАА/	35,000,000
Нийт дүн				2,547,222,988

---oOo---

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

№	Аймаг	Сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	Гүйцэтгэл*	Тайлант оны гүйцэтгэл /хувь/	Он дамжих ажлын гүйцэтгэл /хувь/
				Эхлэх	Дуусах				
1	2	3	4	6	7	9	12	15	
Өмнөх оноос тайлант онд шилжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ									
1	Дорнод	Хэрлэн	Спортын талбай (Хэрлэн сум 3, 11 дугаар баг)	2023	2024	343.6	Хэрэгжиж дууссан	100	
2	Дорнод	Хэрлэн	Гүний худгийн цэвэрлэх гаргах	2023	2024	100.0	Хэрэгжиж дууссан	100	
3	Дорнод	Халхгол	Гүний худгийн цэвэршүүлэх тоног төхөөрөмж (Халхгол сум, Буйр нуур)	2023	2024	117.6	Хэрэгжиж дууссан	100	
4	Дорнод	Хэрлэн	Төрийн байгууллагын албан хэрэгцээнд компьютер, тоног төхөөрөмж	2023	2024	110.5	Хэрэгжиж дууссан	100	
5	Дорнод	Хэрлэн	Дорнод аймагт 2024 онд хэрэгжүүлжээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламжийн геодези, геологийн судалгаа, ТЭЗҮ, зураг төсөв	2023	2024	182.0	Хэрэгжиж дууссан	100	
НИИТ						853.7		100	
Шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ									
1	Дорнод	Хэрлэн	"Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв" ОНБҮГ-ын харьяа барилгууд, барилгын инженерийн шугам, сүлжээг засварлах	2024	2025	177.6	Хэрэгжилт дутуу		50
2	Дорнод	Хэрлэн	Цэцэрлэгийн биений тамирын талбайн тохижилт (Хэрлэн сум, 6 дугаар цэцэрлэг)	2024	2024	20.0	Хэрэгжиж дууссан	100	
3	Дорнод	Хэрлэн	Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн засвар, тохижилт Багц 5 ЦГ	2024	2024	127.8	Хэрэгжиж дууссан	100	
Дорнод	Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн засвар, тохижилт Багц 1		Хэрэгжиж дууссан				100		
4	Дорнод	Хэрлэн	Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн халаалтын систем, гадна, дотор инженерийн шугам сүлжээний их засвар, шинэчлэлт	2024	2024	83.1	Хэрэгжиж дууссан	100	
Дорнод	Хэрэгжиж дууссан						0		
5	Дорнод	Баяндун	Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих (Баяндун, Баян-Уул, Баянгүмэн, Булган, Чойбалсан, Матад, Сэргэлэн, Цагаан-Овоо сумдтай хамтран)	2024	2025	5,747.5	Хэрэгжилт дутуу		48.4
Дорнод	Баян-Уул	Хэрэгжилт дутуу					19		
Дорнод	Баянгүмэн	Хэрэгжилт дутуу					71.2		
Дорнод	Булган	Хэрэгжилт дутуу					50.5		
Дорнод	Чойбалсан	Хэрэгжилт дутуу					49.5		
Дорнод	Матад	Хэрэгжилт дутуу					66		
Дорнод	Сэргэлэн	Хэрэгжилт дутуу					50		
Дорнод	Цагаан-Овоо	Хэрэгжилт дутуу	51.74						
6	Дорнод	Дашбалбар	"Онцгой байдлын үед хэрэглэх хадлан, өвс тэжээлийн агуулах барих" АДААГТ төсөл - 70%, аймаг-15%, Дашбалбар-15%	2024	2024	360.0	Хэрэгжиж дууссан	100	
Дорнод	Халхгол	"Онцгой байдлын үед хэрэглэх хадлан, өвс тэжээлийн агуулах барих" АДААГТ төсөл - 70%, аймаг-15%, Халхгол сум-15%	Хэрэгжиж дууссан				100		
7	Дорнод	Хэрлэн	Төрийн тусгай болон хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж байгаа албан хаагчдад гэрээгээр ашигтнуулах 3 орон сууцны худалдан авах	2024	2024	140.0	Хэрэгжиж дууссан	100	
8	Дорнод	Баян-Уул	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар (Баян-Уул сум)	2024	2025	250.9	Хэрэгжилт дутуу		52
9	Дорнод	Чойбалсан	Эрүүл мэндийн төвийн барилгын "Б" блокийн засвар (Чойбалсан сум)	2024	2025	229.6	Хэрэгжиж дууссан	100	
10	Дорнод	Хэрлэн	Цэцэрлэгийн барилгын засвар (10 дугаар цэцэрлэг)	2024	2024	77.8	Хэрэгжиж дууссан	100	
11	Дорнод	Баян-Уул	Ерөнхий боловсролын бага сургуулийн барилгын засвар (Баян-Уул сум)	2024	2024	132.6	Хэрэгжиж дууссан	100	
12	Дорнод	Гурванзагал	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны барилгын засвар (Гурванзагал сум)	2024	2024	250.0	Хэрэгжиж дууссан	100	
13	Дорнод	Хэрлэн	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын засвар (11 дугаар сургууль)	2024	2025	327.2	Хэрэгжилт дутуу		54
14	Дорнод	Хэрлэн	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын засвар (12 дугаар сургууль)	2024	2024	263.9	Хэрэгжиж дууссан	100	
15	Дорнод	Чойбалсан	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилгын засвар (Чойбалсан сум)	2024	2024	240.1	Хэрэгжиж дууссан	100	
16	Дорнод	Хэрлэн	Төв номын сангийн барилгын гарна засвар	2024	2025	233.5	Хэрэгжилт дутуу		51
17	Дорнод	Хэрлэн	Ахмадын байгууллагад хэрэгцээтэй компьютер, тоног төхөөрөмж (Хэрлэн сум)	2024	2024	29.8	Хэрэгжиж дууссан	100	
18	Дорнод	Гурванзагал, Дашбалбар, Хөлөнбуйр	Соёлын төвд хөгжим, тоног төхөөрөмж (Гурванзагал, Дашбалбар, Хөлөнбуйр сумд)	2024	2024	53.0	Хэрэгжиж дууссан	100	
19	Дорнод	Хэрлэн	Нутгийн удирдлагын байрны барилгын дотоод тохижилт, тоног төхөөрөмж багц1	2024	2024	135.0	Хэрэгжиж дууссан	100	
		Хэрлэн	Нутгийн удирдлагын байрны барилгын дотоод тохижилт, тоног төхөөрөмж багц2				Хэрэгжиж дууссан	100	
		Хэрлэн	Нутгийн удирдлагын байрны барилгын дотоод тохижилт, тоног төхөөрөмж багц3				Хэрэгжиж дууссан	100	
20	Дорнод	Хэрлэн	Төрийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмж	2024	2024	34.3	Хэрэгжиж дууссан	100	

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

21	Дорнод	Хэрлэн	Гамшгаас хамгаалах, Цагдаагийн албаны бэлэн байдлыг хангахад шаардлагатай авто машин (Зүүн бүсийн төв Дорнод аймаг дахь Онцгой байдлын газар, Цагдаагийн газар)	2024	2024	70.0	Хэрэгжиж дууссан	100	
22	Дорнод	Хэрлэн	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Иргэний танхимын тохижилт, тоног төхөөрөмж	2024	2024	63.1	Хэрэгжиж дууссан	100	
23	Дорнод	Хэрлэн	Төрийн тусгай чиг үүргийн болон төрийн байгууллагын албан хэрэгцээнд авто машин багц1 Пургон автомашин Сүмбэрийн 0198-р анги	2024	2024	550.0	Хэрэгжиж дууссан	100	
		Хэрлэн	Төрийн тусгай чиг үүргийн болон төрийн байгууллагын албан хэрэгцээнд авто машин багц2 Цэргийн штабын машин				Хэрэгжиж дууссан	100	
		Хэрлэн	Төрийн тусгай чиг үүргийн болон төрийн байгууллагын албан хэрэгцээнд авто машин багц3 Тамгын газрын машин				Хэрэгжиж дууссан	100	
		Хэрлэн	Төрийн тусгай чиг үүргийн болон төрийн байгууллагын албан хэрэгцээнд авто машин багц4 ШШГА-ны машин				Хэрэгжиж дууссан	100	
24	Дорнод	Хэрлэн	Лабораторийн тоног төхөөрөмж (Шүүх шинжилгээний хэлтэс)	2024	2024	38.0	Хэрэгжиж дууссан	100	
25	Дорнод	Хэрлэн	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих үзэсгэлэн худалдаа, уралдаан тэмцээн зохион байгуулахад шаардлагатай бараа Багц1 Үндэсний бөхийн барилдааны дэвжээ	2024	2024	72.2	Хэрэгжиж дууссан	100	
		Хэрлэн	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих үзэсгэлэн худалдаа, уралдаан тэмцээн зохион байгуулахад шаардлагатай бараа Багц2 Асар майхан				Хэрэгжиж дууссан	100	
26	Дорнод	Хэрлэн	"Дорнод НАА" ОНӨААТҮГ-т шаардлагатай тусгай зориулалтын авто машин, техник хэрэгсэл багц1 Универсаль трактор	2024	2024	410.0	Хэрэгжиж дууссан	100	
		Хэрлэн	"Дорнод НАА" ОНӨААТҮГ-т шаардлагатай тусгай зориулалтын авто машин, техник хэрэгсэл багц2 Бага оврын ачааны машин				Хэрэгжиж дууссан	100	
		Хэрлэн	"Дорнод НАА" ОНӨААТҮГ-т шаардлагатай тусгай зориулалтын авто машин, техник хэрэгсэл багц3 Хулгийн таг хувуу				Хэрэгжиж дууссан	100	
27	Дорнод	Хэрлэн	Хог тээврийн үйлчилгээнд шаардлагатай автомашин худалдан авах (Хэрлэн тохижилт ОНӨААТҮГ)	2024	2024	220.0	Хэрэгжиж дууссан	100	
		НИЙТ				10,337.1		97.0	51.1

